

Ховд аймгийн Статистикийн хэлтэс

Ховд аймгийн ажил эрхлэлтийн танилцуулга

2016 он

Ойлголт, тодорхойлолт, тооцсон аргачлал

Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам - Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч) -ыг *эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам* гэж хоёр ангилна.

Эдийн засгийн идэвхитэй хүн амыг урт хугацаагаар буюу хуанлийн жилээр хэмжигдэх байнгын идэвхитэй хүн ам, нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаагаар хэмжигдэх тухайн үеийн идэвхитэй хүн ам гэсэн хоёр аргаар тодорхойлдог. Энд орсон ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам нь “байнгын идэвхи” гэсэн ойлголтонд тулгуурласан ба нөгөө талаар Монгол улсын хуулиар тогтоосон хөдөлмөрийн насны хүрээнд багтах хүн ам тул 2000 оны хүн ам, орон сууцны тооллого, 2002-2003 болон 2006-2007 оны Ажиллах хүчний түүвэр судалгааны үед хэрэглэсэн “тухайн үеийн идэвхи”-ээр тодорхойлсон эдийн засгийн идэвхитэй хүн амаас зөрүүтэй учир тоо нь өөр өөр байгаа болно. Хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлгүй хүмүүс, хөдөлмөрийн насны суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол хүмүүс ажиллах хүчинд хамрагдаагүй болно.

Ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинж (статус)-д хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ. Аж ахуйн нэгж, байгууллагын орон тоонд ажиллагч, албан бус хөдөлмөр эрхлэгч, гэрээгээр ажил гүйцэтгэгч, улирлын чанартай ажиллагчид, түр ажилтан, бүрэн бус цагаар ажиллагчид мөн ажилтай мөртлөө тодорхой шалтгаанаар (өвчтэй, чөлөөтэй, амралттай г.м) ажиллаагүй хүмүүс хамрагдсан.

Ажилгүйчүүд буюу ажилгүй иргэн – Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай, тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

-“*ажилгүй байсан*” гэж сүүлийн долоо хоногт Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр болон ажил гүйцэтгэх гэрээгээр ямар нэг ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхэлж орлого олоогүй байхыг;

-“*ажил хийхэд бэлэн*” гэж Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас татгалзахгүй байхыг;

-“ажил идэвхтэй хайж байгаа ” гэж ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлж, нэгээс доошгүй удаа ажлын байрны талаар мэдээлэл авсан эсхүл ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих зэрэг ажил олох оролдлого идэвхтэй хийснийг тус тус ойлгоно.

Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин – Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй хүн амыг хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан хувь.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин – Ажиллагчдын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулсан хувь.

Ажилгүйдлийн түвшин – Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулсан хувь.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн хувь – Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулсан хувь.

Хүн ам зүйн ачаалал – Хөдөлмөрийн насны нэг хүн амд ногдох хөдөлмөрийн насанд хүрээгүй, хөдөлмөрийн нас хэтэрсэн хүний тоо

Хөдөлмөр эрхлээгүй хүн ам – Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, хөлсний болон хувиараа хөдөлмөр эрхэлж цалин, хөлс, орлого олдоггүй, хүндэтгэх ба бусад (хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлгүй боловч ажил хайж байгаа, тодорхой шалтгаангүй г.м) шалтгаангаар ажил идэвхитэй эрж хайхгүй байгаа хүн ам. Гэхдээ эдгээрт бүх шатны сургуульд өдрөөр суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол, хөдөлмөрийн насны чадваргүй хүмүүс ороогүй.

Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн ам – Хөдөлмөрийн насны, албан ёсны эрх бүхий байгууллагын нотолгоогоор хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрмөсөн алдсан нь тогтоогдсон хөгжлийн бэрхшээлтэй болон холбогдох хуулийн дагуу тэтгэврийн наснаасаа өмнө тэтгэвэр тогтоолгосон (тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа хүн орохгүй) хүмүүс.

Хөдөлмөрийн насны суралцагчид – Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн анхан болон дунд шатны сургууль,

мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, 6 сараас дээш хугацаагаар мэргэжлийн сургалтанд хамрагдагчид, ЕБС-д суралцаж буй иргэд орно.

Оршил

Хүн амын ажил эрхлэлтийн судалгааны үзүүлэлтүүдийг сум, багийн нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа (Монгол Улсын харьяат, манай улсад удаан хугацаагаар оршин сууж байгаа гадаадын болон цагаач иргэд) суурийн хүн амаар гаргадаг.

Энэхүү судалгаанд аймгийн нийт хүн амын чухам хэдэн хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа, ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагчид, ажилгүйчүүд, ажил эрхлээгүй хүн амын тоо хэд байгаа, хүн ам зүйн ачаалал, ажиллах хүчний хөдөлмөр оролцоо, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин ямар байгааг харуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өгөөжийг тооцож, үнэлэлт дүгнэлт өгч байна.

2015 оны ажиллах хүчний судалгааны үр дүнд үндэслэн Ховд аймгийн ажил эрхлэлтийн танилцуулгыг хийлээ.

1. Судалгаанд хамрагдсан хүн амын тоо, насны бүлэг, байршлаар

Нас	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Хот			Хөдөө		
				Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	39563	39650	79213	12887	13254	26141	26675	26396	53072
0 - 4	5380	5109	10489	1665	1253	2918	3715	3856	7571
5 - 9	4105	4464	8569	1199	1878	3078	2905	2586	5491
10 - 14	3753	4038	7790	1263	1675	2939	2489	2362	4852
15 - 19	3800	3825	7624	1141	886	2027	2659	2939	5598
20 - 24	2485	1982	4466	933	777	1709	1552	1205	2757
25 - 29	2801	2520	5320	724	576	1300	2076	1944	4020
30 - 34	2727	2654	5381	783	942	1725	1944	1712	3656
35 - 39	2740	2937	5677	844	988	1832	1896	1949	3845
40 - 44	3073	3430	6503	1098	1046	2144	1976	2383	4359
45 - 49	3150	3229	6380	1353	1457	2810	1797	1772	3569
50 - 54	2455	2228	4683	939	730	1670	1515	1498	3013
55 - 59	1088	1083	2171	206	311	517	882	772	1654
60 - 64	701	847	1548	265	316	581	436	530	966
65 - 69	499	561	1060	160	105	266	339	456	794
70 +	806	746	1552	314	312	626	492	434	926

Ховд аймгийн хэмжээнд 2015 оны ажиллах хүчний судалгаанд 79213 хүн хамрагдсаны 39563 буюу 49,9 хувь нь эрэгтэй, 39650 буюу 50,1 хувь эмэгтэйчүүд байна.

Байршлаар авч үзвэл 26141 буюу 33,0 хувь хотын хүн ам байсан бол үлдсэн 53072 буюу 67,0 хувь нь хөдөөгийн хүн ам хамрагдсан байна.

2. Ажиллагчид, насны бүлэг, байршлаар

Нас	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	32895	17842	15053	10687	5833	4854	22208	12008	10199
15 - 19	812	624	188	53	53		759	571	188
20 - 24	1910	1206	704	931	566	365	979	640	339
25 - 29	4055	2520	1535	930	724	206	3125	1796	1329
30 - 34	4315	2440	1875	1311	678	632	3004	1761	1243
35 - 39	4904	2543	2362	1520	791	729	3385	1752	1633
40 - 44	5827	2828	2999	1985	990	995	3842	1838	2004
45 - 49	5365	2538	2828	2340	1042	1299	3025	1496	1529
50 - 54	3783	2102	1682	1254	834	420	2530	1268	1262
55 - 59	1376	796	579	258	155	102	1118	641	477
60 - 64	336	141	195	106		106	230	141	89
65 - 69	105		105				105		105
70 +	106	106					106	106	

Нийт судалгаанд хамрагдсан хүн амын 41,5 хувь нь буюу 32895 хүн ам нь ажил эрхэлдэг хүн ам байна. Нийт ажиллагчдын 17842 буюу 54,2 хувь нь эрэгтэйчүүд бол 15053 буюу 45,8 хувь нь эмэгтэйчүүд байна.

Нийт ажиллагчдын 10687 буюу 32,5 хувь нь хотод, 22208 буюу 67,5 хувь нь хөдөөд байна.

Хот болон хөдөөд эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Хотын хүн амын эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт эмэгтэйчүүдийнхээс 16,7 хувь буюу 979 өндөр байна. Харин хөдөөгийн хүн амд эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт эмэгтэйчүүдийнхээс 1809 буюу 15,0 хувиар өндөр байна.

3. Ажилгүй иргэд, хүйс, насны бүлэг, байршлаар

Нас	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	3107	1824	1283	473	259	214	2634	1565	1069
15 - 19	184	85	100				184	85	100
20 - 24	941	579	362	156	103	53	786	477	309
25 - 29	572	233	340	109		109	464	233	231
30 - 34	377	235	142	53	53		324	182	142
35 - 39	236	145	91				236	145	91
40 - 44	239	138	101				239	138	101
45 - 49	452	357	95	104	104		349	253	95
50 - 54	105	52	53	53		53	52	52	

Нийт судалгааны үр дүнгээс 3107 иргэн ажилгүй байна. Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 3107 буюу 3,9 хувь нь ажилгүй иргэн байна.

Ажилгүй иргэдийн 473 буюу 15,2 хувь нь хотод, 2634 буюу 84,8 хувь нь хөдөөд байна. Нийт ажилгүй иргэдийн 58,7 хувь нь буюу 1824 нь эрэгтэй, 41,3 хувь буюу 1283 нь эмэгтэй хүн байна.

Насны бүлэг	15 - 19	20 - 24	25 - 29	30 - 34	35 - 39	40 - 44	45 - 49	50 - 54
Бүгд	184	941	572	377	236	239	452	105
Дүн эзлэх хувь	5.9	30.3	18.4	12.1	7.6	7.7	14.6	3.4

Нийт ажилгүй иргэдийг насны бүлгээр авч үзвэл хамгийн өндөр буюу 30,3 хувь буюу 941 иргэн 20-24 насныхан эзлэж байгаа бол, хамгийн бага 3,4 хувь нь буюу 105 иргэн 50-54 насны бүлэг байна.

4. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, хүйс, насны бүлэг, байршлаар


Нас	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
				Эрэгтэй	Эмэгтэй			Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	16363	6659	9704	6047	2667	3380	10316	3992	6324
15 - 19	6628	3092	3536	1974	1088	886	4654	2003	2651
20 - 24	1615	699	916	623	264	359	992	436	557
25 - 29	693	48	645	261		261	432	48	384
30 - 34	689	53	637	362	53	309	327		327
35 - 39	536	53	484	312	53	260	224		224
40 - 44	437	108	330	159	108	52	278		278
45 - 49	562	255	306	366	208	158	196	48	148
50 - 54	795	301	494	364	106	258	431	195	236
55 - 59	795	292	503	259	51	209	536	242	294
60 - 64	1211	560	651	475	265	210	736	295	441
65 - 69	955	499	456	266	160	105	690	339	351
70 +	1446	700	746	626	314	312	820	386	434

Эдийн засгийн идэвхгүй хүн ам нийт судалгаанд хамрагдсан хүн амын 16363 буюу 20,6 хувийг эзлэж байна. Нийт эдийн засгийн идэвхгүй хүн амын 40,7 хувь нь 6659 иргэн эрэгтэй, 59,3 хувь нь 9704 эмэгтэй хүн ам байна.

Эдийн засгийн идэвхгүй хүн амын 6047 буюу 36,9 хувь нь хотын хүн ам, 10316 буюу 63,1 хувь нь хөдөөний хүн ам байна.

Насны бүлэг	15 - 19	20 - 24	25 - 29	30 - 34	35 - 39	40 - 44	45 - 49	50 - 54	55 - 59	60 - 64	65 - 69	70 +	Нийт дүн
Дүн	6628	1615	693	689	536	437	562	795	795	1211	955	1446	16363
Дүнд эзлэх хувь	40.5	9.9	4.2	4.2	3.3	2.7	3.4	4.9	4.9	7.4	5.8	8.8	100

Эдийн засгийн идэвхгүй хүн амын 40,5 хувь нь буюу 6628 хүн ам 15-19 насныхан, 9,9 хувь нь буюу 1615 хүн ам 20-24 насныхан, хамгийн бага буюу 2,7 хувийг 40-44 насныхан эзлэж байна.



5. Ажиллагчид, хүйс, боловсролын түвшин, байршлаар

Боловсролын түвшин	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	32895	17842	15053	10687	5833	4854	22208	12008	10199
Боловсролгүй	618	472	146	104	104	0	515	369	146
Бага	2645	1741	904	256	256	0	2389	1485	904
Суурь	6138	3707	2431	1140	829	311	4998	2878	2120
Бүрэн дунд	11087	5698	5389	3521	2023	1499	7566	3675	3891
Техникийн болон мэргэжлийн	3345	2405	940	883	469	414	2462	1937	525
Тусгай мэргэжлийн дунд	1523	659	864	465	260	204	1058	399	660
Дипломын дээд болон бакалавр	7383	3107	4276	4267	1893	2374	3116	1214	1902
Магистр	156	52	104	51	0	51	104	52	52

Ажиллагчдын 54,2 хувь эрэгтэй, 45,8 хувь нь эмэгтэй иргэн байна. Ажиллагчдын боловсролын түвшнээр дүнд эзлэх хувиар авч үзвэл :

	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын дээд болон бакалавр	Магистр
Дүн	618	2645	6138	11087	3345	1523	7383	156
Дүнд эзлэх хувь	1.9	8.0	18.7	33.7	10.2	4.6	22.4	0.5

Ажиллагчдыг боловсролын түвшнээр авч үзвэл бүрэн дунд болон дипломын дээд болон бакалавр боловсролтой хүн амын ажил эрхлэлт бусад боловсролтой хүн амаас өндөр байна. Бүрэн дунд боловсролтой хүн амын ажил эрхлэлт боловсролгүй иргэдийн ажил эрхлэлтээс 31,8 пунктээр, бага боловсролтой хүн амын ажил эрхлэлтээс 25,7 пунктээр, суурь боловсролтой хүн амын ажил эрхлэлтээс 15 пунктээр тус тус их байна.

5. Ажиллагчид, хүйс, эдийн засгийн салбар, байршлаар

Эдийн засгийн салбар	Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	32895	17842	15053	100	100	100
ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур	13564	7647	5917	41.2	42.9	39.3
Уул уурхай, олборлолт	1300	1001	298	4.0	5.6	2.0
Боловсруулах үйлдвэрлэл	1433	1082	351	4.4	6.1	2.3
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	360	360	0	1.1	2.0	0.0
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент	155	102	53	0.5	0.6	0.3
Барилга	1777	1432	345	5.4	8.0	2.3
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	5267	1799	3468	16.0	10.1	23.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1756	1711	45	5.3	9.6	0.3
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	962	203	759	2.9	1.1	5.0
Мэдээлэл, холбоо	53	53	0	0.2	0.3	0.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	105	0	105	0.3	0.0	0.7
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	157	103	54	0.5	0.6	0.4
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	53	53	0	0.2	0.3	0.0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын	1516	870	647	4.6	4.9	4.3
Боловсрол	2880	1017	1862	8.8	5.7	12.4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1259	264	995	3.8	1.5	6.6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	157	55	102	0.5	0.3	0.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	142	90	52	0.4	0.5	0.3

Ажиллагчдыг эдийн засгийн салбараар авч үзвэл хамгийн өндөр буюу 41,2 хувийг ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуурын салбар эзлэж байгаа бол 0,2 хувийг Мэдээлэл холбооны салбар болон Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа эзлэж байна.

ХАА, ойн аж ахуйн салбарт ажиллагчдын 7647 буюу 56,4 хувийг эрэгтэйчүүд, 5917 буюу 43,7 хувийг эмэгтэйчүүд эзлэж байна.

ХАА салбарын дараа 16,0 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбар эзлэж байна. Уг салбарт 5267 хүн ам ажиллаж байна. 5267 хүн амын 1799 буюу 34,1 хувь нь эрэгтэй, 3468 буюу 65,9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Мэдээлэл холбооны салбар болон Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт тус тус 53 хүн ажиллаж байна.

7. Ажиллагчид, хүйс, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, байршлаар

Хөдөлмөр эрхлэлтийн статус	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
				Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй
Бүгд	32895	17842	15053	10687	5833	4854	22208	12008	10199
Цалин хөлстэй ажиллагч	11333	6079	5254	5857	3127	2730	5475	2952	2524
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	8060	5114	2946	4158	2553	1605	3902	2561	1341
Мал аж ахуй эрхлэгч	11946	6447	5499	204	102	102	11742	6345	5397
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	1556	202	1354	468	52	416	1089	150	938

Нийт ажиллагчдын 11333 буюу 34,4 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 8060 буюу 24,5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 11946 буюу 36,3 хувийг мал аж ахуй эрхлэгч, 1556 буюу 4,8 хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч эзлэж байна.

Нийт цалин хөлстэй ажиллагчдын 51,6 хувь нь буюу 5857 иргэн хотод, 48,4 хувь нь буюу 5475 иргэн хөдөөд ажиллаж амьдарч байна.

Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчдын ихэнх нь буюу 87 хувийг эмэгтэйчүүд эзлэж байна. Энэ байдал хот, хөдөөд ч мөн адил өндөр хэвээр байна.

Хөдөөд ажиллагчдын хувь хотын ажиллагчдаас 35 хувиар буюу 11521 хүнээр их байна.

8. Ажилгүй иргэд, хүйс, боловсролын түвшин, байршлаар

Боловсролын түвшин	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
				Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй
Бүгд	3107	1824	1283	473	259	214	2634	1565	1069
Боловсролгүй	135	135	0	0	0	0	135	135	0
Бага	368	281	87	0	0	0	368	281	87
Суурь	450	398	52	52	52	0	398	346	52
Бүрэн дунд	1131	536	595	157	104	53	974	432	542
Техникийн болон мэргэжлийн	80	80	0	0	0	0	80	80	0
Дипломын дээд болон бакалавр	888	339	549	265	104	161	623	236	387
Магистр	55	55	0	0	0	0	55	55	0

Ажилгүй иргэдийн 1824 буюу 58,7 хувь нь эрэгтэйчүүд, 1283 буюу 41,3 хувийг эмэгтэйчүүд байна.

Ажилгүй иргэдийн 135 буюу 4,3 хувийг боловсролгүй иргэд, 368 буюу 11,8 хувийг бага боловсролтой иргэд, 450 буюу 14,5 хувийг суурь боловсролтой иргэд, 1131 буюу 36,4 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, 80 буюу 2,6 хувийг техникийн болон мэргэжлийн боловсролтой иргэд, 888 буюу 28,5 хувийг дипломын дээд болон бакалаврын боловсролтой иргэд үлдсэн 55 буюу 1,9 хувийг магистрын боловсролтой иргэд тус тус эзлэж байна.

Ажилгүй иргэдийн 15,2 хувийг хотын иргэд эзлэж байгаа бол 84,8 хувийг хөдөөний иргэд эзлэж байна.

9. Ажилгүй иргэд, шалтгаан, насны бүлэг, хүйсээр

	V.92. Таны ажилгүй байсан шалтгаан юу вэ?				Total
	Тухайн жилд сургууль төгссөн	Мэргэжил, дадлага туршлага байхгүй	Мэргэжилд тохирох ажил олдохгүй	Ажил хайгаад олдохгүй байгаа	
Бүгд	156	1404	414	1134	3107
15 - 19		51	36	97	184
20 - 24	156	490	96	200	941
25 - 29		290	236	46	572
30 - 34		183	46	148	377
35 - 39		136		100	236
40 - 44		94		145	239
45 - 49		107		346	452
50 - 54		53		52	105
Эрэгтэй	52	908	179	685	1824
15 - 19			36	49	85
20 - 24	52	388	44	96	579
25 - 29		88	99	46	233
30 - 34		140		95	235
35 - 39		92		52	145
40 - 44		94		44	138
45 - 49		107		250	357
50 - 54				52	52
Эмэгтэй	104	495	235	449	1283
15 - 19		51		49	100
20 - 24	104	102	52	104	362
25 - 29		202	137		340
30 - 34		43	46	52	142
35 - 39		44		48	91
40 - 44				101	101
45 - 49				95	95
50 - 54		53			53

Нийт ажилгүй иргэдийн 156 буюу 5 хувь нь тухайн жилд сургууль төгссөн, 1404 буюу 45,2 хувийг мэргэжил, дадлага туршлага байхгүй, 414 буюу 13,3 хувийг мэргэжилд тохирох ажил олдохгүй, 1134 буюу 36,5 хувийг ажил хайгаад олдохгүй байгаа гэсэн шалтгаантай байна.

Тухайн жилд сургууль төгссөн 156 иргэдийн 67 хувийг эмэгтэйчүүд эзлэж байгаа бол үлдсэн 33 хувийг эрэгтэйчүүд эзлэж байна.

Эрэгтэйчүүдэд мэргэжилийн дадлага туршлага байхгүй болон ажил хайгаад олдохгүй байгаа гэсэн шалтгаанууд дийлэнх хувийг эзлэж байгаа бол эмэгтэйчүүдийн хувь тухайн жилд сургууль төгссөн болон мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа гэсэн шалтгаанууд дийлэнх хувийг эзлэж байна.

10. Албан бус сектор дахь ажиллагчдын тоо, хүйс, насны бүлэг, байршлаар

Албан бус сектор		Үндсэн	Давхар
Бүгд		5559	200
Нас	21 - 24	157	
	26 - 29	302	52
	31 - 34	394	
	36 - 39	1207	52
	41 - 44	1113	49
	46 - 49	1102	
	51 - 54	863	47
	56 - 59	369	
	71 +	52	
Бүгд	Эрэгтэй	3481	151
Нас	25 - 29	250	52
	30 - 34	185	
	35 - 39	914	52
	40 - 44	820	
	45 - 49	488	
	50 - 54	560	47
	55 - 59	211	
	70 +	52	
Бүгд	Эмэгтэй	2078	49
Нас	20 - 24	157	
	25 - 29	51	
	30 - 34	209	
	35 - 39	293	
	40 - 44	293	49
	45 - 49	614	
	50 - 54	303	
	55 - 59	157	
	Байршил	Хот	3159
	Хөдөө	2400	200

Албан бус секторт 5559 иргэн ажил эрхэлж байгаа бол, 200 иргэн үндсэн ажлынхаа хажуугаар давхар албан бус секторт ажил эрхэлж байна. Албан бус секторт ажиллагчдын 3481 буюу 62,6 хувь нь эрэгтэйчүүд, 2078 буюу 37,4 хувь нь эмэгтэйчүүд байна. Албан бус секторт 36-39 насныхан хамгийн өндөр буюу 1207 хүн 21,7 хувийг эзлэж байна.

Албан бус секторт ажиллагчдын 3159 буюу 56,8 хувь нь хотод, 2400 буюу 43,2 хувь нь хөдөөд ажиллаж байна.

11. Үндсэн ажлаараа албан бус секторт ажиллагчдын тоо, салбараар

		Үндсэн		Total
		Хүйс		
		Эрэгтэй	Эмэгтэй	
Үүнээс : салбараар	Уул уурхай, олборлолт	128		128
	Боловсруулах үйлдвэрлэл	665	105	769
	Барилга	49	150	199
	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	1168	1485	2652
	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1217	45	1262
	Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	151	241	392
	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	51		51
	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	54	52	106
Нийт дүн		3481	2078	5559

Албан бус секторт ажиллагчдын хамгийн өндөр хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ 2652 буюу 47,7 хувийг эзлэж байна.

Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ салбарын дараа 1262 буюу 22,7 хувийг тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар эзлэж байна. Хамгийн бага болох 51 буюу 0,9 хувийг мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбар эзлэж байна.

12. Давхар ажлаараа албан бус секторт ажиллагчдын тоо, салбараар

		Давхар		Total
		Хүйс		
		Эрэгтэй	Эмэгтэй	
Үүнээс : салбараар	ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур	99		99
	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	52		52
	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын		49	49
Нийт дүн		151	49	200

Давхар ажлаараа албан бус секторт ажилладаг 200 хүн байгаагийн 99 буюу 49,5 хувийг ХАА салбар, 52 буюу 26 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ, 49 буюу 24,5 хувийг Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын салбарт ажиллагчид эзлэж байна.

**13. Үндсэн ажлаараа албан бус секторт ажиллагчдын тоо, хүйс,
ажил мэргэжлийн ангиллаар**

		Үндсэн		Total
		Хүйс		
		Эрэгтэй	Эмэгтэй	
Үүнээс : ажил мэргэжлийн ангиллаар	Менежер	51		51
	Мэргэжилтэн	51		51
	Худалдаа, үйлчилгээний ажилтан	1161	1726	2887
	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	825	307	1132
	Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	1172		1172
	Энгийн ажил, мэргэжил	222	45	267
Нийт дүн		3481	2078	5559

Албан бус секторт ажиллагчдын 51,9 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 21 хувийг машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагчаар, 20,3 хувийг үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан мэргэжилээр тус тус ажиллаж байна.

**14. Давхар ажлаараа албан бус секторт ажиллагчдын тоо, хүйс, ажил
мэргэжлийн ангиллаар**

		Давхар		Нийт дүн
		Хүйс		
		Эрэгтэй	Эмэгтэй	
Үүнээс : ажил мэргэжлийн ангиллаар	Мэргэжилтэн		49	49
	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	99		99
	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	52		52
Нийт дүн		151	49	200

Үндсэн ажлынхаа хажуугаар албан бус секторт давхар ажил эрхэлдэг 200 хүний 151 буюу 75,5 хувь нь эрэгтэй, 49 буюу 24,5 хувь нь эмэгтэйчүүд байна. Албан бус секторт давхар ажил эрхэлдэг 49 эмэгтэй мэргэжилтэн хийдэг бол 151 эрэгтэй ХАА ажилтан болон үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан мэргэжилээр ажиллаж байна.

**Баруун бүсийн аймгуудын хөдөлмөр эрхлэлтийн зарим
үзүүлэлтүүдийн зэрэгцүүлэлт / судалгааны үр дүнгээр /**

Баруун бүсийн аймгууд	Ажил эрхлэлтийн түвшин					Хөдөлмөр эрхлээгүй хүний тоо				
	2011	2012	2013	2014	2015	2011	2012	2013	2014	2015
Баян-Өлгий	92.9	87.6	54.3	56.2	63.4	3160	6389	10531	10425	5869
Увс	89.1	91.6	69.9	65.7	70.1	2952	3177	3777	5064	3279
Ховд	81.8	92.0	60.6	61.1	62.8	6693	2994	2102	3938	3107
Говь-Алтай	89.7	86.3	66.6	65.3	70.2	4225	4183	2895	2717	2403
Завхан	91.3	93.6	68.0	77.3	68.2	3279	2547	2077	1501	2218
Улсын дундаж	92.3	91.8	57.0	57.2	56.9	87030	94705	94732	95856	92672

Судалгааны үр дүнгээр тооцсон ажил эрхлэлтийн түвшингээр баруун бүсийн аймгуудын дотроос хамгийн бага хувийг Ховд аймаг, хамгийн өндөр хувийг Говь-Алтай аймаг эзлэж байна. Хөдөлмөр эрхлээгүй хүний тоогоор баруун бүсийн аймгуудаас хамгийн өндөрт Баян-Өлгий аймаг, хамгийн багад Завхан аймаг орж байна.

Ховд аймаг улсын дунджаас 5,9 пунктээр өндөр байна. Баруун бусад Говь-Алтай ажил эрхлэлтийн түвшнээр хамгийн өндөр байгаа бөгөөд энэ нь улсын дунджаас 13,3 пунктээр өндөр байна.

Ажилгүйдлийн үзүүлэлтүүд
/ Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр /

Аймаг	Ажилгүйдлийн түвшин					Ажилгүйчүүдийн тоо				
	2011	2012	2013	2014	2015	2011	2012	2013	2014	2015
Баян-Өлгий	7.0	12.4	23.5	22.5	11.9	1038	6389	10531	10425	5869
Говь-Алтай	10.8	13.7	10.8	10.2	8.8	787	4183	2895	2717	2403
Завхан	18.2	6.4	5.6	4.0	6.9	1457	2547	2077	1501	2218
Увс	10.4	8.4	10.1	14.8	8.5	781	3177	3777	5064	3279
Ховд	8.6	8.0	6.3	11.7	8.6	2132	2994	2102	3938	3107
Баруун бус	10.8	9.8	11.9	13.3	9.2	6195	19290	21382	23645	16876
Улсад	7.7	8.2	7.9	7.9	7.5	57171	94705	94732	95856	92672

2015 оны судалгааны үр дүнгээр хамгийн их ажилгүйчүүдтэй аймаг Баян-Өлгий, хамгийн бага ажилгүйчүүдтэй аймаг Завхан аймаг байна. Ховд аймаг ажилгүйдлийн түвшнээр баруун бүсдээ 3-рт орж байна. Энэ нь улсын дунджаас 1,1-ээр өндөр бол бүсийн дунджаас 0,6 пунктээр бага байна.

Баруун бүсийн ажилгүйчүүдийн 34.8 хувийг, улсын хэмжээний нийт ажилгүйчүүдийн 6.3 хувийг эзэлж байна.

Дүгнэлт

1. Хот болон хөдөөд эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Хотын хүн амын эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт эмэгтэйчүүдийнхээс 16,7 хувь буюу 979 өндөр байна. Харин хөдөөгийн хүн амд эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт эмэгтэйчүүдийнхээс 1809 буюу 15,0 хувиар өндөр байна.
2. Ажилгүй иргэдийн 473 буюу 15,2 хувь нь хотод, 2634 буюу 84,8 хувь нь хөдөөд байна.
3. Нийт ажилгүй иргэдийг насны бүлгээр авч үзвэл хамгийн өндөр буюу 30,3 хувь буюу 941 иргэн 20-24 насныхан эзлэж байгаа
4. Эдийн засгийн идэвхгүй хүн амын 40,5 хувь нь буюу 6628 хүн ам 15-19 насныхан, 9,9 хувь нь буюу 1615 хүн ам 20-24 насныхан, хамгийн бага буюу 2,7 хувийг 40-44 насныхан эзлэж байна.
5. Ажиллагчдыг боловсролын түвшнээр авч үзвэл бүрэн дунд болон дипломын дээд болон бакалавр боловсролтой хүн амын ажил эрхлэлт бусад боловсролтой хүн амаас өндөр байна.
6. Ажиллагчдыг эдийн засгийн салбараар авч үзвэл хамгийн өндөр буюу 41,2 хувийг ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуурын салбар эзлэж байгаа бол 0,2 хувийг Мэдээлэл холбооны салбар болон Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа эзлэж байна.
7. Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчдын ихэнх нь буюу 87 хувийг эмэгтэйчүүд эзлэж байна.
8. Эрэгтэйчүүдэд мэргэжилийн дадлага туршлага байхгүй болон ажил хайгаад олдохгүй байгаа гэсэн шалтгаанууд дийлэнх хувийг эзлэж байгаа бол эмэгтэйчүүдийн хувь тухайн жилд сургууль төгссөн болон мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа гэсэн шалтгаанууд дийлэнх хувийг эзлэж байна.
9. Албан бус секторт ажиллагчдын хамгийн өндөр хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ 2652 буюу 47,7 хувийг эзлэж байна
10. Ховд аймаг улсын дунджаас 5,9 пунктээр өндөр байна. Баруун бусад Говь-Алтай ажил эрхлэлтийн түвшнээр хамгийн өндөр байгаа бөгөөд энэ нь улсын дунджаас 13,3 пунктээр өндөр байна.
11. Хотод ажилын байр нэмэгдүүлэх шаардалагатай байгааг уг судалгааны үр дүнгээс харж болохоор байна.
12. Монгол улсад ХАА-н салбараар бусад салбараа хөгжүүлвэл ажил хийх боломжтой хүн ам их байна.

Ашигласан ном, материалууд

1. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2011, 2012, 2013, 2014,2015 он
2. Ховд аймгийн нийгэм, эдийн засгийн байдал танилцуулга 2013, 2014, 2015 он
3. Ажиллах хүчний судалгааны 2015 оны үр дүнгийн тайлан
4. Статистик мэдээллийн нэгдсэн сан: www.1212.mn